

АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
I.1 Төлийн талаарх мэдээлэл	3
I.2 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц	4
I.3 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа	4
I.4 Уурхайн ажиллах горим	4
I.5 Баяжуулалтын технологи	5
I.6 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг	6
II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд	8
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	13
III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	13
III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.	14
III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	14
IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	16
IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах.....	22
IV.4 Нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
IV.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
IV.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	24
IV.7 Хог хаягдлын менежмент	26
IV.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	28
V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1 Төслийн талбайн байршил.....	3
Зураг № 2 Угаан баяжуулах технологийн схем	5
Зураг № 3. Уурхайн цахилгаан хангамжийн схем.....	6
Зураг № 4. Төслийн талбайд байрлуулсан хогийн бункер.....	7
Зураг № 5 Ургамал сумын агаарын температурын норм.....	9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 Талбайн газар зүйн солбицол	3
Хүснэгт № 2. Уурхайн ажиллах горим	5
Хүснэгт № 3 Төслийн талбайн ажилчдын хотхоны усны хэрэглээ	7
Хүснэгт № 4 Ил уурхайн усны хэрэглээ	7
Хүснэгт № 5 Баяжуулах хэсгийн усны хэрэглээ.....	8
Хүснэгт № 6 Унд ахуйн усны хэрэглээ.....	10
Хүснэгт № 7 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
Хүснэгт № 8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт № 9 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
Хүснэгт № 10 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ..	23
Хүснэгт № 11 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт № 12 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт № 13 Орчны шинжилгээний хөтөлбөр	29
Хүснэгт № 14. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	31
Хүснэгт № 15 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал.....	32
Хүснэгт № 16 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	33


I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төлийн талаарх мэдээлэл

Төслийн байршил: “Од” нэртэй MV-020628 дугаартай тусгай зөвшөөрлийн талбай нь Завхан аймгийн Ургамал сумын нутагт, байр зүйн зургийн М-46-128 дугаартай хавтгайд байрлана.

MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газар нь 1639.24 га эзэлдэг бөгөөд талбай нь ерөнхийдөө урдаас хойш 4.9 км, баруунаас зүүн тийш 5.1 км хэмжээтэй.

MV-020628 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай хайгуул явуулсан талбай нь засаг захиргааны хувьд Завхан аймгийн Ургамал сумын нутагт хамаарна. Ургамал сумын төвөөс баруун урагш 27 км, Улаанбаатар хотоос баруун хойш 1250 гаруй км, Завхан аймгийн төвөөс БХ 226 орчим км зайд байдаг.



Зураг № 1 Төслийн талбайн байршил

Хүснэгт № 1 Талбайн газар зүйн солбицол

Талбайн булангийн цэгүүд	Өргөрөг	Уртраг
1	93° 59' 50.00"	48° 24' 20.40"
2	93° 59' 50.00"	48° 21' 30.30"
3	93° 59' 42.60"	48° 21' 30.30"
4	93° 59' 39.30"	48° 21' 37.30"
5	93° 59' 34.84"	48° 21' 37.24"
6	93° 57' 30.00"	48° 21' 37.24"
7	93° 57' 30.00"	48° 23' 30.00"
8	93° 56' 30.00"	48° 23' 30.00"
9	93° 56' 30.00"	48° 24' 14.60"
10	93° 56' 44.80"	48° 24' 14.60"
11	93° 56' 50.50"	48° 24' 15.00"
12	93° 56' 50.50"	48° 24' 20.40"

Төсөл хэрэгжүүлэгч: “Форсголд Майнинг” ХХК нь Монгол улсын 9011622079 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, 7-р хороолол, Шинэ дэлхий телевизийн байр 803 тоот. Утас:77100909

I.2 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц

Ордын нөөц: Тус ордын MV-020628 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлт талбайн үлдэгдэл нөөц 2022 оны 01-р сарын 01-ний өдрийн байдлаар ордын нөөц бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 1,035.32 мг/м³ алтны дундаж агуулгатай 232.79 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 240.41 кг, алт (химийн цэврээр) 215.91 кг нөөц байна. Ил уурхайг ашиглах явцад олборлолтын үеийн хаягдал болон тээвэрлэлтийн үеийн хаягдал үүсэхгүй байхаар тооцоход 826.80 мг/м³ алтны агуулгатай 264.45 мян.м³ үйлдвэрлэлийн нөөц ба үүнээс 81.2%-ийг буюу 214.52 мян.м³ бодитой (В) зэрэглэлийн нөөц, 18.8%-ийг буюу 49.93 мян.м³ боломжтой (С) зэрэглэлийн нөөц тус тус эзэлж байна. Энэхүү нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын хавсралтын 3.1.2-н заалтын дагуу магадласан үйлдвэрийн (В') нөөц рүү шилжүүлэв. Ашиглалтын MV-020628 тоот тусгай зөвшөөрөлт талбайн хөрсний зузаан их болон алтны агуулга бага хэсэгт эдийн засгийн хувьд үр ашиггүй нөхцөлөөс хамааран ордын бодитой болон боломжтой (В+С) нөөцийн зэрэглэлээр 613.52 мг/м³ алтны дундаж агуулгатай 36.44 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 22.36 кг, алт (химийн цэврээр) 20.02 кг нөөц ил уурхайн гадна үлдэж байна. Мөн тус ордын тусгай зөвшөөрлийн хилийн гадна буюу XV-017729 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлийн талбайд 2022 оны 01-р сарын 01-ний өдрийн байдлаар бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 699.44 мг/м³ алтны дундаж агуулгатай 30.23 мян.м³ элс, үүнээс алт (шлихээр) 21.15 кг, алт (химийн цэврээр) 18.95 кг нөөц байна.

I.3 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа

Төсөл захиалагчаас ирүүлсэн ТЭЗҮ боловсруулах техникийн ажлын даалгавар, угаан баяжуулах хэсгийн хүчин чадалд тулгуурлан ил уурхайн хүчин чадлыг 130.0 мян.м³/жил, хоногт 612 м³ элс олборлохоор төлөвлөв. Уг хүчин чадалд тулгуурлан ордын ашиглалтын хугацааг тооцоолоход 3 жил байна.

I.4 Уурхайн ажиллах горим

Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ВАХТ-ын системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн олборлолт болон элс угаалтын ажлыг 4-р сараас 10-р сар хүртэл үргэлжлэлхээр тооцоолж ТЭЗҮ(тодотгол-I)-ийг боловсруулав. Ил уурхайн горимыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт № 2. Уурхайн ажиллах горим

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Жилийн календарь хоног	хоног	365
2	Төлөвлөгөөт засварын хоног	хоног	18
3	Төлөвлөгөөт сул зогсолтын хоног	хоног	151
4	Жилд ажиллах бодит хоног	хоног	196
5	Жид ажиллах календарь цаг	цаг	8,760
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	-	2
7	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
8	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	24
9	Жилд ажиллах бодит хугацаа	цаг	3,920
10	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент	-	0.76
11	Ээлж солилт (цайны цаг, түлш цэнэглэлт, тосолгоо, засвар үйлчилгээ)	цаг	1.0
12	Ээлж солилт (ээлж солилт)	цаг	1.0
13	Хоногт ажиллах бодит цаг	цаг	20
14	Цаг ашиглалтын коэффициент	-	0.83

I.5 Баяжуулалтын технологи

Цагаан толгой ордын дээж нь хялбар угаагдах ангилалд хамаарагдаж байна. Баяжуулах хэсэгт тоног төхөөрөмжүүд нэг шугамаар байрлан ажиллана. Элс хүлээн авах бункерт алт агуулагч элсийг утгуурт ачигчаар ачин шигшүүрт оруулж 20 мм шигшүүрээр угаан ангилна.


Шигшүүрээс гарсан 20 мм-ээс бага хэмжээтэй элсийг шлюзээр баяжуулна. 20 мм-ээс том хэмжээтэй элсийг гаалийн овоолгод хураана. Шлюзээс гарсан баяжмалыг гүйцээн баяжуулах хэсэгт сэгсрэх ширээгээр баяжуулан шлихийн алтыг гаргаж авна. Гүйцээн баяжуулах хэсгийн сэгсрэх ширээний хаягдал өөрийн урсгалаар хаягдалын санд хуримтлагдана. Тунаах нууранд хуримтлагдсан усыг цэвэршүүлэх далан руу тунаан технологийн эргэлтийн ус болгон дахин ашиглана. Элс угаан баяжуулах хэсгийн технологийн схемийг дор харуулав.



Зураг № 2 Угаан баяжуулах технологийн схем

I.6 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг

Цахилгаан хангамж: Цахилгаан эрчим хүчээ дизель үүсгүүрээр шийдсэн. Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгч нь уурхайн тосгоноос гадна ил уурхайн гэрэлтүүлэг, ус хангамжийн хэсэг, элс угаан баяжуулах цех зэрэг байх болно. Мөн түүнээс гадна ашиглалтын туршид засварын газар, шатахуун түгээгүүр зэрэг хэрэглэгчид цахилгаан эрчим хүч хэрэглэнэ.



Зураг № 3. Уурхайн цахилгаан хангамжийн схем

Хог хаягдал: Төслийн талбайгаас гарах хатуу хог хаягдлыг хог хаягдлын цэгт цуглуулан авч Завхан аймгийн Ургамал сумын ЗДТГ-тай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлыг нэгдсэн цэг рүү ачуулна.

“Цагаан толгой” алтны шороон ордын хэмжээнд ахуйн гаралтай, үйлдвэрийн гаралтай (засвар үйлчилгээнээс гарах хаягдал) гэсэн 2 төрлийн хог хаягдал гардаг. Ахуйн гаралтай хог хаягдлын түр цэгийг салхин дор, ажилчдын гэр байрнаас 100 м зайд байрлуулсан.

Хог хаягдлын цэгийг байгуулахдаа хатуу, шингэнээр нь ялган хаяж байхаар төлөвлөсөн бөнөөд ингэхдээ мөн дахин ашиглагдах, эс ашиглагдахаар нь ялгаж байна.



Зураг № 4. Төслийн талбайд байрлуулсан хогийн бункер

Усан хангамж: Уурхайн усан

хангамжийг гүний худгаар хангах юм.

Унд ахуйн ус: Нэг хүний хоногийн усны хэрэглээний нормыг БОНХАЖЯ–ны 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301-р тушаалын хавсралт 12-т заасан ус хэрэглээгээр “Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр” гэсэн нөхцлийг сонгон авч нэг хүний өдөрт хэрэглэх усны нормыг 80 литр байна гэж тооцов. Ундны ба ахуйн хэрэглээний усны хэмжээг уурхайн хүчин чадлын өсөлттэй уялдуулан уурхайд туслан гүйцэтгэгчид, хяналт шалгалт, гэр бүлийн хүмүүс түр ирэх зэргийг тооцоолон үзэхэд уурхайд 70 хүртэл хүн амьдран суух болно.

Хүснэгт № 3 Төслийн талбайн ажилчдын хотхоны усны хэрэглээ

Уурхайн тосгоны усны хэрэглээ

Усны норм	Нийт ажилчид	Уурхайн ажиллах хоног	Хоногт хэрэглэх усны хэмжээ	Нийт ус хэрэглээ
80 литр	70 хүн	196 хоног *3 жил	5600 литр буюу 5.6 м ³	1096.4 м ³ /жил
Энэхүү уурхайн нь 3 жил ажиллах хугацаандаа 3292.8 м ³ буюу 3.29 мян.м ³ усыг унд ахуйд ашиглах тооцоолол гарлаа.				

Зам талбайн усалгаа: Ил уурхайд шаардлагатай технологийн ус хангамжид уурхайн дотоод замын тоос дарах, ногоон байгууламж, талбайн усалгаа болон тоног тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай усны хэрэглээ багтана. Тооцоогоор орд ашиглалтын хугацаанд ойролцоогоор 17.2 мян.м³ усыг зам талбайн усалгаанд ашиглахаар байна.

Хүснэгт № 4 Ил уурхайн усны хэрэглээ

Орд ашиглалтын жил	Замын хэмжээ			Хоногт услах тоо, ш	Жилд услах тоо, ш	Усны зарцуулалт	
	Усалгааны замын урт, м	Зорчих хэсгийн өргөн, м	Талбай, м ²			Норм, л/м ²	Жилд хэрэглэх усны хэмжээ, м ³
1-р жил	4,610.00	10	46,100.00	1	56	2	5,163.20
2-р жил	5,380.00	10	53,800.00	1	56	2	6,025.60
3-р жил	5,410.00	10	54,100.00	1	56	2	6,059.20
Нийт							17,248.00

Баяжуулах хэсгийн усны хэрэглээ: Ордын ойр орчимд гүний худгууд гарсан бөгөөд эдгээрийн дундаж гүн 65 метр орчим гүнтэй худгууд тогтоогдсон. Иймд уурхайн усны нөөцийг гүний худгийн байгууламжаар бүрдүүлэн үйлдвэрлэлийн болон ундны усны хэрэглээгээ хангахаар төлөвлөсөн. Үйлдвэрлэлд шаардлагатай нэмэлт усыг худгийн усаар хангахаар төлөвлөсөн ба уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд байрлах үүсмэл нууруудыг ашиглахаар төлөвлөсөн. Баяжуулах технологийн шат дамжлагаас гарах технологийн усыг баяжуулах цехэд дахин ашиглана. Технологийн тооцоогоор 1 м³ элс угаахад 4 м³ технологийн ус зарцуулна.

Хүснэгт № 5 Баяжуулах хэсгийн усны хэрэглээ

Элс угаан баяжуулах хэсгийн усны хэрэглээ	Баяжуулах элсний хэмжээ, мян.м3	Ус хэрэглээний норм 4м ³	Технологийн ус ашиглалтын коэффициент, %	Эргэлтийн усны хэмжээ, 73%	Шаардлагатай цэвэр усны хэмжээ, мян.м3
1-р жил	32410.73	129642.9	73	94639.33	35003.59
2-р жил	108102.53	432410.2	73	315659.4	116750.7
3-р жил	123938.34	495753.4	73	361900	133853.4
Нийт	264451.6	1057806.0	73	772198.7	285607.7

II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй: “Цагаан толгой” алтны шороон ордын уурхай нь физик газарзүйн мужлалаараа Монгол орны баруун хойд хэсэгт Их нууруудын хотгорын мужид байрлана.


Уур амьсгал: Завхан аймаг нь Монголын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн мужид багтана. Хамгийн их халуун /30⁰С ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -30-40 хэм байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.

II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Завхан аймаг 82 мянган хавтгай дөрвөлжин километр нутагтай. Хангайн нуруу түүний ноён оргил Отгонтэнгэр /4031м/, Хангайн нуруунаас салбарласан далайн түвшнээс 2500-3100м өргөгдсөн Ганц, Загастай, Дахт, Солонгот, Халзан Согоот зэрэг сүрлэг өндөр уулс даваануутай.

Хамгийн их халуун /30⁰С ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -30-40 хэм байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-

205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.



Зураг № 5 Ургамал сумын агаарын температурын норм

Агаарын температур: Завхан аймгийн нийт нутагт жилийн дундаж салхины хурд ууландаа 2.0м/с, говь хээрт 3.1м/с хүрдэг. Ялангуяа хавартаа салхи ихтэй байдаг. 15м/с –ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо олон жилийн дунджаар 7-22 байна. Салхины хамгийн их хурд 20-40м/с хүрдэг байна. Шороон шуургатай өдрийн тоо уулархаг болон тал хээрийн бүс нутгаар 29-76 хоног. Харин Улиастай, Дөрвөлжин сумдын нутгаар 80-105 хоног байдаг байна. Өвөл, зунд салхины зонхилох чиглэл солигдож хавар, намар шилжилтийн байдалтай байх боловч орчны урсгал, газар нутгийн нөлөөнөөс өвөрмөц байдалтай байдаг.

Агаарын дундаж температур олон жилийн дунджаас 1.2 градусаар дулаарсан цаашид дулааралтын эрчимшил нэмэгдэнэ. Агаарын харьцангуй чийгшил 30 ба түүнээс бага байх өдрийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Хур борооны шинж байдал өөрчлөгдөж зүс бороо цөөрч харин аадар бороо орох тохиолдол ихэссэн. Хүчтэй салхи, шороон шуургатай хоногийн тоо жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс бид салбар бүрт, иргэн бүр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эерэг дадлыг бий болгох, тухайн газар нутгийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд мод тарих, ногооруулах, ажлыг эрчимтэй хийх нь чухал юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийг орон нутагтаа, сум бүр ажил хэрэг болгож үр дүнтэй хэрэгжүүлэх нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгахад маш чухал нөлөөтэй юм гэдгийг онцолмоор байна.

Агаарын температур нь аливаа нутгийн уур амьсгалын үндсэн шинжийг илтгэгч гол үзүүлэлт болдог. Олон жилийн агаарын температур 0.7 градусаас хасах 6.9 градус хэлбэлзэнэ. Өөрөөр хэлбэл жилийн дундаж температурын агууриг 7.6 градус болж байна. Жилийн дундаж агаарын температур аймгийн нутгийн баруун, баруун өмнөөс зүүн, зүүн хойшоо хүйтэрсэн тархалттай байна.

Жилийн хүйтэн сар нь аль ч нутагтаа нэгдүгээр сар байдаг. Тухайлбал, аймгийн хойд болон зүүн хэсгээр сарын дундаж температур 28-32 градус хүрч, хахир хүйтэн өвөл болдог байна. Зарим хүйтэн өвөл Хангайн нуруу, Тарвагатай, Булнай, Тагнын нурууны сав нутгаар 49-56 градус хүрч хүйтэрдэг. Харин жилийн дулаан сар нь долоодугаар сар байх бөгөөд хамгийн дулаан нь Завхан голын дагуу Монгол элсний ар орчим болон их нуурын хотгорын сав орчмоор 17-21 градус бусад нутгаар 14-18 градус дулаан байдаг. Зуны улиралд хөрсний гадаргад 54-68 градус хүртэл халдаг учраас хөрсний гадаргын температурын хэлбэлзэл бүр ч их буюу 110-127 байдаг.

Хөрсөн бүрхэвч: Хөрсний ерөнхий шинж нь ялзмагаар ядмаг карбонатжилт өндөртэй, ус чийгээр дутагдалтай нимгэн бор хөрс болно. Хөрс нь шаварлаг, элсэрхэг, сайргархаг, дайргархаг найрлагатай бөгөөд эдгээр нь өөр өөрийн бүрэлдэх орчинтой байна. Хөндий хотгорын төв хэсгээр шаварлаг, мараалаг хөрс тохиолдох ба сайргархаг дайргархаг бор хөрс нь ил гарсан хад чулуу бүхий толгой, бэл хормойгоор нимгэн бүрхэвч үүсгэж байдаг. Уулсын өндөрлөг газруудаар элгэн хүрэн өнгийн нарийн мөхлөгт хөрс ховроор тохиолддог онцлогтой. Орон нутаг нь салхи, хуурайшилт ихтэй учир элэгдлийн гадаргуутай бөгөөд хөрс нь хийсэж зулгарах нөхцөлтэй юм.

Гадаргын ерөнхий хэлбэр дүрсийн хувьд орой хэсгээрээ хадархаг нам уулс болон түүний энгэр, бэлийн системийг хамран төслийн талбайн байрших бөгөөд хөрсний үүсвэрийн үйл явцад хажуугийн зөөгдлийн үйл явц голчлон оролцох учир хөрс үүсгэгч эх чулуулаг нь делюви, пролювийн хайрган хурдас дээр тогтворжсон нимгэн ялзмагт давхаргатай, сайр чулуурхаг, уулын хээрийн хар хүрэн хэв шинжийн хөрс зонхилон тархсан байна (Д.Доржготов, 2003).

Хөрсний ерөнхий шинж нь ялзмагаар ядмаг карбонатжилт өндөртэй, ус чийгээр дутагдалтай нимгэн бор хөрс болно. Хөрс нь шаварлаг, элсэрхэг, сайргархаг, дайргархаг найрлагатай бөгөөд эдгээр нь өөр өөрийн бүрэлдэх орчинтой байна.

Амьтны аймаг: Ургамал сум орчмын нутаг нь ус намаг, говь, тал хээрийн гэсэн байгалийн хэд хэдэн үндсэн биотопуудтай учир экологийн бичил орчнууд нь олон зүйл амьтад орж ирж нутагших нөхцлийг бүрдүүлдэг.

Төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэрийн хувьд Говь хээрийн бүсэд, газар зүйн мужлалын хувьд их нууруудын хотгортой зах залгаа нам дор газар оршино. Сумын нутаг дэвсгэр нь уул, толгод бүхий тал хээр газар юм.

Ургамал сумын нутагт туурайтан амьтдаас хар сүүлт байсан гэдэг боловч сүүлийн жилүүдэд харагдахаа больсон байна. Харин өндөр уулын бүсэндээ цөөн тоогоор аргаль янгир байдаг байна. Махчин амьтдаас чоно, үнэг, хярс амьдрахаас гадна хэвлээр явагч могой, гүрвэл нилээд элбэг үзэгдэнэ.

Ургамлын нөмрөг: Тус нутагт амьтан ургамлын аймгийн экосистемийн шинж төрх алдагдаж энэ хавийн ургамлын зүйлийн бүрдэлд хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд голлох болжээ. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт ургамлын аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны тэсвэртэй, дасан зохицох чадвартай ургамлууд байгаа болно.

Ургамал сум нь ургамал газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Дагуур Монголын (Төв Азийн) дэд их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон-Сэлэнгийн дэд мужид хамаарагдана (БНМАУ-ын үндэсний атлас, 1990).

Ургамал сумын нутаг дэвсгэрийн хувьд Говь хээрийн бүсэд, газар зүйн мужлалын хувьд их нууруудын хотгортой зах залгаа нам дор газар оршино. Сумын нутаг дэвсгэр нь уул, толгод бүхий тал хээр газар юм.

Ургамал сум нь ургамалжилтын ангиллаар тэгш тал газрын цөлийн хээр, тэгш талын хээр ба хуурай хээр бөгөөд Ургамал сумын нутаг дэвсгэрт дараах ургамлан бүлгэмдлүүд тархсан байна.Үүнд:

- Тэгш талын хээр ба хуурай хээр
- Тэгш тал газрын цөлийн хээр
- Нуур хөндийн нуга, марзлаг бэлчээр
- Сийрэг ургамалтай элс
- Сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр
- Намгархаг, нам дор газрын газрын бэлчээр
- Хээрийн нуга сийрэг
- Марзлаг бэлчээр

Дэд бүтэц, нийгэм эдийн засгийн байдал: Завхан аймаг нь Монгол улсын аймаг юм. 1923 онд байгуулагдсан. 24 сум, 114 багатай, 16580 хүн амтай (2021 оны эцсээр) бөгөөд хүн ам өсөж байна. Аймгийн төв Улиастай сум нь Улаанбаатар хотоос 1021 км-т оршдог. Улиастай сум нь Агьт, Баян-Улаан, Худаг, Жаргалант, Солоон, Хэрэмт, Зуслангийн ам, Товцог, Өндөр толгой уулын бэлчээр хиллэн Алдархаан сумын нутгийн төв хэсэгт оршдог.

Сумын хэмжээнд 79709 толгой малтайгаас 26 тэмээ, 2432 адуу, 2692 Үхэр, 33076 хонь, 41483 ямаа байна. Сумын хэмжээгээр нийт 79.9 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 10.3 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 12.8 хувь байна. 200 малчин өрх, 623 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 14.6 хувийг эзэлж байна.

Сумын төсвийн нийт орлого нь 1343,7 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг 237,7 сая төгрөг, сумын өөрийн орлого 1106,0 сая төгрөгийн орлогоос бүрддэг. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 501,4 сая төгрөг байна. Нийт зардлын 59.8 хувь нь цалин, 6.6 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 33.6

хувийг нь бусад зардал эзэлж байна.Сумын хэмжээнд нийт 400 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 9,8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 237,7 сая төгрөг, орон нутагт 1106,2 сая төгрөг нийт 1343,7 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд 300-400 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Завхан баялаг ХХК, Нарантуул шим ХХК, Завхан хүнс группын салбар зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн хэмжээ нь өсч байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Форсголд майнинг” ХХК-ийн хэрэгжүүлэх төслийн байршил, техник-технологийн шийдэл төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” аргыг хэрэглэн үр дүнг нь доорх хүснэгтэд илэрхийлэв.

Хүснэгт № 6 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий	Уурхайн барилга байгууламж, ил уурхайгаар эвдрэлд орно	Төслийн талбайд	Их
Агаар	Олон хүний хөдөлгөөн, машин механизмын яндангаас гарах утаанаас болж агаар бохирдоно.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Хөрсөн бүрхэвч	Төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	Талбайн ургамал болон төслийн талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Ус	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгарагчаас ус бохирдож болзошгүй	Төслийн талбай орчим	Бага

III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.
- Ажиллагсдын агаарын чанарын стандарт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах дүрэм, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, зааварчилгаа өгөх, сургалт явуулах
- Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.
- Уурхайн тээвэрлэлтийн шороон замд том оврын тээврийн хэрэгслийн нөлөөгөөр тоосжилт ихээр бий болж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хаягдлын аж ахуйд эргэлтийн усны систем ашиглан үйлдвэрлэлийн хаягдалтай хамт хаягдсан усыг цэвэрлэн үйлдвэрлэлд эргүүлэн хэрэглэх шаардлагатай бөгөөд орон нутгийн хөрсний шингээлт, ууршилтын тайлангүй учир бусад үйлдвэртэй харьцангуйгаар технологийн нийт хэрэгцээт усны 80%-ийг эргүүлж ашиглахаар тооцоолсон байна. Тоног төхөөрөмжүүдийн цэвэрлэгээ болон бусад хэрэгцээнд бүх технологийн усны 15-20%-ийг хэрэглэнэ.

- Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдож болзошгүй.
- Ахуйн хатуу, шингэн хог хаягдалдаа зөв менежмент явуулаагүйгээс болж гүний ус бактер болон химийн бохирдолд орж болзошгүй.
- Технологийн хэрэгцээндээ шаардлагатай усыг газрын доорх уснаас ашиглаж байгаа тул газрын доорх усны нөөц баялаг багасах
- Ахуйн бохир хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.
- Уурхайн техник хэрэгсэлд ашиглагдах шатах тослох материал алдагдсанаас болж хөрсөн бүрхэвч хүнд металаар бохирдож улмаар гүний усанд нэвчих

III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороонд дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй
- Уг төсөл хэрэгжсэнээр тухайн төслийн талбай түүний орчмын бэлчээрийн талбай хомсодно.
- Хөрс хуулалт болон шимт хөрсийг хадгалах явцад хөрсний үржил шим нь алдагдах

III.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.
- Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах ажлыг байнга хийнэ.
- Тус ордыг илуурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас амьтны зүйлд үзүүлэх шууд нөлөөлөл харьцангуй бага бөгөөд харин тус байгууламжийн бүтээн байгуулалтын үед хөрсөнд болон хөрсөн дээр

амьдардаг хорхой шавж газар шорооны ажлын үед устах хөрстэй хамт зөөгдөх, дайжин алга болж болзошгүй.

- Тоосжилтоос үүдэн төслийн талбай түүний орчмын хөрс, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж ингэснээр амьтадын зүйлийн идэш тэжээлд дам байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлэх талтай.
- Хөрс, ургамлын нөмрөгт төслийн үйл ажиллагаанаас бохирдол үүсвэл тухайн ургамал, хөрснөөс хоол тэжээлээ олж иддэг амьтдын зүйлд дам байдлаар сөргөөр нөлөөлж амьтны зүйл хордож, үхэж үрэгдэж болзошгүй.
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, олборлолт явуулахад газар шорооны ажил хийгдэж тоосжилт үүсэж ургамлын нөмрөг тоосонд дарагдана.

IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Форсголд Майнинг” ХХК нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар шинэчлэн баталсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу “Цагаан толгой” алтны шороон ордны 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

“Цагаан толгой” алтны шороон ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгалийн нөөц баялагийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

“Цагаан толгой” алтны шороон ордын 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тусгалаа.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Зардлын утга	Нэг жилийн зардал мян.төг
1	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	4800.0
2	Нөхөн сэргээлтийн зардал	25000.0
3	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	4000.0
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал	685.0
5	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний зардал	702.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2425.0
7	Удирдлага зохион байгуулалтын зардал	5000.0
	Нийт	37640.0

IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Цагаан толгой” алтны шороон орд ашиглах төслийн байгаль хамгаалах төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бохирдлыг багасгах, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах багасгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг доорхи хүснэгтүүдэд бүрэн эхээр харуулав.

Хүснэгт № 7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин								
Орчны тоосжилт үүсэх	Уурхайн талбайд хуурайшилт, тоосжилт ихтэй үед уурхайн гол зам, талбайг услах	Ил уурхайн талбайн хэмжээнд	Мян.төг	Үйл ажиллагааны зардалаар		Үйл ажиллагааны зардалаар	Хуурайшилт ихтэй болон салхи ихтэй өдрүүдэд	Агаарын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль
